



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/95

Батноров сум

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон
Шалгаруулалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам", сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай" 11 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт тодотголд тусгагдсан 8 (найман) нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 03- ний өдөр зарлаж Газрын биржийн цахим систем болон олон нийтийн цахим сүлжээгээр олон нийтэд мэдэгдэхийг Газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Төслийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 12⁰⁰ цаг хүртэл хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Газрын даамал (Э.Зулцэцэг)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

Батноров сумын Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын 25-ны
өдрийн 11/9 тоот захирамжийн
хавсралт

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ,
ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

№	Төлөвл өл тийн нэгж талбар	Газрын зориулалт	Байршил	Талбайн хэмжээ [m2]	Төсөл хүлээж авах хугацаа	
					Эхлэх	Дуусах
1	4120461	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	2-р баг, Эхэнбүрд Бага булаг	30000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
2	4120462	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	2-р баг, Эхэнбүрд Бага булаг	30000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
3	4120460	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	1-р баг, Эрдэнэман্দмань Бэрхийн хөндий	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
4	4117766	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	5-р баг, Идэрмэг, Олон нуур	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
5	4117765	1623: Мал аж ахуйн үйлдвэрлэл	1-р баг, Эрдэнэман্দмань, Нуурын толгой	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
6	4117769	1624: Мал аж аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	4-р баг, Баянбулаг, Төмстийн ар	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
7	4117768	1624: Мал аж аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	4-р баг, Баянбулаг, Төмстийн ар	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
8	4117767	1624: Мал аж аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	4-р баг, Баянбулаг, Төмстийн ар	50000	2024-07-02 08:30	2024-07-08 12:00
Дүн				360000		